

“МОНГОЛ ЗАЛУУ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий дахинд залуучуудыг улс орны хөгжлийг тодорхойлогч, эх орны ирээдүйн эзэд хэмээн хүлээн зөвшөөрч, тэдний асуудалд анхаарлаа хандуулж, тэдний өмнө тулгардаг асуудлуудыг шийдвэрлэхэд өөрсдийнх нь оролцоог хангах, хөгжих боломж олгоход чиглэсэн тухайлсан төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2014 оны эцсээр гэхэд судалгаанд хамрагдсан нийт 198 улс орнуудаас 122 нь залуучуудад чиглэсэн бодлого, хөтөлбөртэй байна.¹

Монгол улсын хүн амын 38.5 хувийг 15-34 насныхан эзэлдэг бөгөөд энэ нь хүн амын бусад бүлгүүдийн дундаас хамгийн олонх болж байна.² Иймд тэдэнд тулгарч буй нийтлэг асуудал бэрхшээлийг тодорхойлж, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, залуу гэр бүлийн суурь хэрэгцээг хангахад төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх, зөв бодлого, зорилтот арга хэмжээнүүд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол улс бичиг үсэг тайлагдалтын хувьд өндөр түвшинд буюу 2010 оны судалгаагаар 15-24 насныхны бичиг үсэг тайлагдалт 98.5 хувьтай байна.³ Сургуульд сурч байгаа 15-19 насныхны эзлэх хувь 2000 онд 47 хувьтай байсан бол 2010 онд 79 хувь болж огцом өссөн байна.⁴ 2000 онд залуучуудын дөнгөж 6 хувь нь дээд боловсрол эзэмшиж байсан бол 2010 онд 22 хувь болон өссөн байна.⁵ Эдгээр үзүүлэлтүүдээс манай улсад боловсролын хүртээмж боломжийн хэмжээнд байгааг харж болох боловч, Дэлхийн эдийн засгийн форумын хүний нөөцийн илтгэлд дурдагдсанаар боловсролын чанараар харьцангуй доогуур буюу 122 орноос 76-д эрэмбэлэгдсэн байна.⁶

Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хувьд сургуульд хамрагдалт 15-17 насныхан 47-55 хувьтай, 18-19 насныхан 29-39 хувьтай, 20-24 насныхан 14-20 хувьтай, 25-29 насныхан 5-8 хувьтай байна.⁷ Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын

¹ “The state of youth policy in 2014”, <http://www.youthpolicy.org/blog/2014/05/state-of-youth-policy-2014/>

² “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн нэгдүгээр бүлэг 3 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

³ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн гуравдугаар бүлэг, нэгдүгээр хэсэг, 4 дэх тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

⁴ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн гуравдугаар бүлэг, нэгдүгээр хэсэг, 6 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

⁵ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн дөрөвдүгээр бүлэг, нэгдүгээр хэсэг, 7 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

⁶ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн гуравдугаар бүлэг, нэгдүгээр хэсэг, 12 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

⁷ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн гуравдугаар бүлэг, нэгдүгээр хэсэг, 9 дэх тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

боловсрол эзэмших нөхцөл, боломжийг бүх шатны сургууль хангалттай бүрдүүлээгүй байгаатай холбоотой юм.

Эрүүл мэндийн яамны өвчлөл мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийн дагуу 2013 оны байдлаар залуучуудын өвчний тэргүүлэх шалтгаанд шээс бэлгийн тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин, осол гэмтэл, хордлого бусад гадны шалтгаан, амьсгалын замын өвчин, мэдрэлийн тогтолцооны өвчин, зүрх судасны өвчин, хавдар зэрэг өвчин орсон байна.⁸ Мөн түүнчлэн 15-29 насны залуучуудын нас баралтын тоо 2010-2012 оны судалгааны үзүүлэлтээр нийт хүн амын нас баралтын тооны 17,2 хувийг эзэлж байна.⁹

Эдгээр нь залуучуудын эрүүл бус амьдралын хэв маяг, хорт зуршлын зохисгүй хэрэглээ, чанартай эрүүл хүнс ногоо хэрэглэх боломж хомс, буруу хооллолт, хөдөлгөөний дутагдал, хэт таргалалт, бэлгийн зан үйл, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн талаар мэдлэг мэдээлэл хомс, өвчнөөс урьдчилсан сэргийлэх талаар тодорхой мэдлэггүй байгаа зэрэг шалтгаантай холбоотой талаар Хүний хөгжлийн илтгэл 2014-д дурдсан байна.¹⁰ Иймд залуучуудын эрүүл мэндийн асуудалд чиглэсэн зохистой арга хэмжээг тодорхой үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Монгол Улсын Засгийн газраас 2013 онд “Ажилтай орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Ажилгүйдлийн түвшний 2013 оны судалгаагаар 15-29 насны ажилгүй залуу эрэгтэйчүүдийн тоо 46,2 хувь, залуу эмэгтэйчүүдийн тоо 36,9 хувь байсан бол 2014 оны байдлаар ажилгүй залуу эрэгтэйчүүдийн тоо 43,6 хувь, залуу эмэгтэйчүүдийн тоо 41,6 хувь болж буурсан байна.¹¹ Ажилгүйдлийн түвшин өмнөх оноо бодвол тодорхой хувиар буурч байгаа боловч нийт залуучуудын тэн хагас нь ажилгүй хэвээр байсаар байна.

НҮБ-ын Хүн амын сангийн 2013 онд хийсэн судалгаагаар ажил хөдөлмөр эрхэлж байгаа залуучуудын 62,6 хувьд тэдний орлого хүрэлцдэггүй, өдөр тутмын хэрэгцээгээ хангаж чаддаггүй гэсэн дүн гарсан байна.¹² Энэ чиглэлд төрийн байгууллагууд болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангаж, цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Залуу гэр бүл, залуучуудын урд тулгарч буй нэн тэргүүний асуудлуудын нэг нь хувийн орон байртай болох юм. Залуучуудын дунд 2010 онд явуулсан суурь судалгаанд оролцсон залуучуудын амьдралд нэн тэргүүнд хэрэгцээтэй зүйлсийн нэгдүгээрт орон байртай болох орсон байна.¹³ Монголын залуучуудын холбооноос гаргасан судалгаагаар залуучуудын 62,3 хувь нь өөрсдийн хувийн орон байргүй буюу

⁸ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн гуравдугаар бүлэг, хоёрдугаар хэсэг, 3 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

⁹ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн гуравдугаар бүлэг, хоёрдугаар хэсэг, 4 дэх тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

¹⁰ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн гуравдугаар бүлэг, хоёрдугаар хэсэг, 5-6 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

¹¹ Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн дөрөвдүгээр бүлэг, хоёрдугаар хэсэг, 13 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

¹² “Төрөөс залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлогын зөвлөмж” 50 дахь тал, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүн амын сантай хамтарсан судалгаа, УБ., 2013 он

¹³ “Төрөөс залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлогын зөвлөмж” 49 дэх тал, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүн амын сантай хамтарсан судалгаа, УБ., 2013 он

эцэг эхийнхээ болон түрээсийн, хамаатан садангийн, албан байгууллагынхаа байранд амьдардаг байна.¹⁴ Энэ чиглэлд Монгол Улсын Засгийн газраас 2013 онд “Орон байрны ипотекийн зээлийн ерөнхий журам”-ыг батлан хэрэгжүүлж байна. Цаашид ипотекийн зээлээс гадна, залуучуудын орон байрны хэрэгцээг хангах төрөл бүрийн шийдлүүдийг бий болгоход төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Залуучуудын улс орны хөгжилд гар бие оролцох, нийгэмд эзлэх байр суурийг бий болгоход тэдний нийгмийн харилцаан дахь оролцоо үүргийг нэмэгдүүлэх явдал чухал юм. Залуучуудын дунд оролцооны талаар хийсэн 2011 оны судалгаанаас залуучуудын оролцоо маш чухал, залуучууд улсаа авч явна гэх үзэл 86,3 хувьтай байна.¹⁵ Эндээс залуучууд улс орны хөгжилд гар бие оролцох, шийдвэр гаргах түвшний хэмжээнд оролцох хүсэлтэй болохыг харуулж байна.

Нийгмийн бүхий л салбар дахь асуудлаар залуучуудын дуу хоолойг сонсож, тэдний гаргасан санал санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлэлтийн шатан дахь тэдний бодит оролцоог бий болгох, залуучуудын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж тэдэнтэй хамтарч ажиллах талаар үр дүнтэй механизмыг бүрдүүлэх шаардлага байсаар байна.

Залуучуудын сурч боловсрох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн зохих үйлчилгээг үнэ төлбөргүй авах, улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй залуучууд адил буюу тэгш эрхээр хангагдах зэрэг олон эрх зөрчигдсөөр байна. Гэсэн хэдий ч залуучуудын эрхийн зөрчилтэй холбоотой судалгаа статистик мэдээлэл дутагдалтай байгаа нь бодлогын энэ чиглэлийг тодорхойлоход бэрхшээл үүсгэж байна. Залуучууд хүний эрхийн үнэлэмж, эрх зүйн боловсрол дутмаг байгаагаас бусдыгаа үл хүндэтгэх, ялгаварлах явдал түгээмэл байна. Залуучуудын эрхийг хангахад чиглэсэн, тэдэнд эрх зүйн боловсрол олгох, зөвлөгөө өгөхөд чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, тэдэнд чиглэсэн төрийн бодлого, хөтөлбөр боловсруулах, шаардлагатай арга хэмжээг авахдаа нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэг болох хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, нэн ядуу, өнчин, орон гэргүй, хараа хяналтгүй хүүхэд, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт байгаа хүүхдүүд, өрх толгойлсон залуу эцэг, эх, бусдын туслалцаагүйгээр бие даан өдөр тутмын үйлдлээ гүйцэтгэх боломжгүй залуучууд, хорих ангид хоригдож буй залуучуудыг тэгш хамруулах, тэдэнд тулгардаг асуудлыг тусгайлан авч үзэх улмаар дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын дунд ялангуяа хэл ярианы согог болон танин мэдэхүйн согог зэрэг төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бараг тал хувь буюу 47 хувь нь боловсролгүй бичиг үсэг тайлагдаагүй байна.¹⁶ Энэ нь тэд бусад залуучуудын адил эрхээ эдэлж чадахгүй байгаагийн зөвхөн нэг илрэл юм.

¹⁴ “XXI зуун-Монголын залуучууд” суурь судалгаа, Монголын залуучуудын холбоо, УБ., 2011 он

¹⁵ “XXI зуун-Монголын залуучууд” суурь судалгаа, Монголын залуучуудын холбоо, УБ., 2011 он

¹⁶ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн нэгдүгээр бүлэг 9 дэх тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

Иймд дээрх нийгмийн дэмжлэг хэрэгтэй залуучуудад тулгарч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд төрөөс хэрэгжүүлж буй залуучуудын цогц бодлого нь нийгмийн бүхий л салбарт тэдгээр залуучуудын оролцоог хангах, тэдэнд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байх шаардлагатай юм.

Залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлыг бодитой тодорхойлох, залуучууд руу чиглэсэн бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнг хянах, үнэлэх, шаардлагатай өөрчлөлтийг хийхийн тулд залуучуудын олонхыг хамарсан, бодит нарийвчилсан судалгааг жил бүр тогтмол гаргаж байх шаардлагатай юм.¹⁷ Өнгөрсөн хугацаанд Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Яам, “НҮБ-ын Хүн амын сан”, “НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр”, “Дэлхийн зөн Монгол” зэрэг олон улсын байгууллагууд, “Монголын залуучуудын холбоо” ТББ, “Нээлттэй нийгэм форум” ТББ, Шинжлэх Ухааны Академийн Философи, Социологи, Эрхийн Хүрээлэн зэрэг цөөхөн хэдэн байгууллага залуучуудын талаар судалгаа явуулжээ. Залуучууд, тэдэнд тулгарч буй асуудлын талаар судалгаа хийх төрийн бус байгууллагууд, судлаачдын тоог нэмэгдүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх шаардлага байсаар байна.

Хөгжиж буй орны хувьд манай улсын залуучуудад эрүүл байх, чанартай боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдах, орлогоо нэмэгдүүлэх, хувийн орон байртай болох, улс орны асуудалд шийдвэр гаргах түвшинд оролцох, улс төрийн болон нийгмийн оролцоогоо нэмэгдүүлэх зэрэг асуудлууд тулгамдсаар байна.

Монгол улсын төрөөс залуучуудыг дэмжих, хөгжүүлэх чиглэлд хамаарах дараах бодлого, хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого (2008), Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2004), Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн төлөөр баримтлах бодлого (2003), Монгол улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого (1999), Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого (2009), Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого (2001), Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2006), “Ажилтай орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөр (2013 он), “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2012), Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2012) зэргийг дурдаж болох юм.

Бодлого, хөтөлбөрүүд нь залуучуудын бүлгийг тодорхой хүрээнд багтаасан боловч “Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-өөс бусад нь тухайлан залуучууд рүү шууд чиглэсэн үйл ажиллагаа явуулаагүй байна. Тус хөтөлбөр нь 2007-2015 он хүртэлх гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд залуучуудын эрүүл мэндийг сайжруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх, олон улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий мэдлэг, боловсрол эзэмшүүлэх, мэдээллийг цаг үеэсээ хоцролгүй хүртэх боломж нөхцөлийг нэмэгдүүлэх зэрэг багц үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж ирсэн байна.

Хэдий тийм боловч энэхүү хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт үнэлгээ хийх механизм тодорхойгүй, хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцах эзэн, төрийн

¹⁷ Draft Mongolian Youth Policy Framework - Төрөөс залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлогын эхний төсөл 39 дэх тал, Андреас Карстен, Гер, 2014 он

байгууллагуудын үүргийн хуваарилалт тодорхой бус, хөтөлбөрөөр тусгагдсан арга хэмжээ хэрэгжүүлэх бодит санхүүжилт хангалтгүй байсан. Залуучуудын бодлого болон бусад хөтөлбөрүүдэд иргэний нийгмийн байгууллагууд, залуучуудын оролцоог хангах, дэмжих талаар хангалттай төлөвлөсөн байгаа ч хэрэгжилтийн шатанд бодит оролцоо хангалтгүй болсон байна.

Хүн ам, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төрийн албан хаагчид болон нийгмийн ажилтнууд амархан халж солигддог, тогтворгүй байдлаас болж мэдлэг, мэдээлэл дутмаг хүмүүс богино хугацаанд ажилладаг болсон нь хөгжлийн цогц үйлчилгээг залгамж холбоотойгоор үзүүлэх боломжийг бууруулах болсон.

Залуучуудын нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах идэвхтэй иргэн болгон төлөвшүүлэх бодлогыг дэлхий нийтээр баримтлах болсон байна. Энэ нь хүн амд залуучуудын эзлэх хувь нэмэгдсэн, дэлхий нийтийн хөгжилд даяарчлалтай холбоотой шинэ нөхцөл байдал бий болж, залуучуудын санаа бодлыг сонсож, шийдвэр гаргах болон хөгжлийн үйл явцад тэдний идэвхтэй санаачилга, дуу хоолой, оролцоог хангах, эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх шаардлага гарч байгаатай холбоотой.

Залуучуудын боловсрол, эрүүл мэнд, нийгмийн байр суурьт нөлөө үзүүлэгч гол хүчин зүйл нь ажилгүйдэл, бага орлогоор тайлбарлагдаж байна. Дээд боловсрол эзэмшихээс өөрөөр ажил орлоготой байх арга зам байхгүй мэтээр боддог хандлага залуучуудын дунд газар авч юунд ч хамаагүй суралцаж гэрчилгээ, дипломтой болохыг эрхэмлэснээс чанаргүй их, дээд сургуулиуд олон болсон, их дээд сургуульд элсэн орж чадаагүй, доогуур орлоготой өрхийн хүүхдүүд арга барагдсан байдлаар мэргэжлийн сургуульд орж суралцдаг байдлаас үүдэн хүний амьдралын өдөр тутамд хэрэгцээтэй, хөдөлмөрийн зах зээлд хамгийн эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын нэр хүнд, чанар буурсан.

Хөгжлийн бэрхшээлтэй болон нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсгийн асуудлыг зөвхөн материаллаг тусламжаар шийдвэрлэх арга барилтай байдаг нь тэдний бие даан хөгжих боломжийг хааж байна.

Иймд залуучуудын бодит хэрэгцээг тэдний санал санаачилгад үндэслэн төрөөс дэмжлэг үзүүлэх байдлаар тусгаж, залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, олон улсад хэрэгжүүлж байгаа шинэлэг, үр дүнтэй үйл ажиллагааны аргачлал, иргэний нийгмийн байгууллагуудын хуримтлуулсан туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн залуу хүн бүрийг улс орны хөгжлийн асар их нөөц, ирээдүй, идэвхтэй түншлэгч гэж үзэж тэдний хэрэгцээг тодорхойлж, хүний эрхийг хангахад анхааран дэлхий нийтийн, бүсийн, үндэсний стратегид тулгуурлан, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас дэвшүүлсэн залуучуудын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд болон 2014 оны Бакугийн залуучуудын бодлогын талаарх чуулга уулзалтаар авсан амлалтуудыг үндэс болгосон хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлага урган гарч ирж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зарчим

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрөөс залуучуудын талаарх баримтлах бодлогын дараах зарчмуудыг баримтална:

2.1.1. Залуучуудыг эх орныхоо өнөө ба ирээдүйн хөгжилд чухал үүрэгтэй бөгөөд нийгэм дэх эерэг хүч гэж үнэлнэ.

2.1.2. Залуучуудын төрөлхийн болон үндэсний, олон улсын эрх зүйн хүрээн дэх аливаа эрхийг нь хүндэтгэн эдлүүлэхэд төрийн бодлого чиглэгдэнэ.

2.1.3. Залуучуудыг иргэний харьяалал, нас, хүйс, яс үндэс, шашин шүтлэг, итгэл үнэмшил, оюуны болоод бие махбодын чадвар, бэлгийн чиг хандлага, боловсролын түвшин, хувь хүний бодит ба бусдад ойлгогдох онцлогоос хамаарах аливаа ялгаварлал, гадуурхлаас ангид байлгана.

2.1.4. Залуучууд хувийн болон нийгмийн амьдралын бүхий л хүрээнд өөрсдийн хэрэгцээ шаардлага, хүсэл эрмэлзлэлийн үндсэн дээр адил тэгш боломжоор хангагдана.

2.1.5. Залуучуудыг өөрсдийн амьдралд нь нөлөө үзүүлэхүйц, чухал ач холбогдолтой бодлого, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, тэдгээр үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхөд оролцуулна.

2.1.6. Залуучуудын бодлогын төлөвлөлт, хэрэгжүүлэлт, тэдгээрийн дүн шинжилгээ нь нотолгоо баримтад үндэслэсэн, залуучуудын бодит хэрэгцээ, олон улсын стандарт, тэргүүн туршлагад тулгуурласан, салбар хоорондын уялдааг цогцоор нь хангасан байна.

2.1.7. Залуучуудын бодлого нь тууштай, залгамж холбоотой байх бөгөөд энэ чанар нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцаанд өөрчлөлт орох, Засгийн газар шинээр байгуулагдах, төрийн захиргааны тогтолцоо, бүтцэд өөрчлөлт оруулахад орхигдох ёсгүй.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1. Хөтөлбөрийн зорилго нь төрөөс залуучуудын талаарх баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд залуучуудыг нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд идэвхтэй оролцох, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах оролцоог нэмэгдүүлэх орчныг бүрдүүлэх замаар өөрийн, гэр бүлийн болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, хуулиар олгогдсон үүрэг, эрхээ ухамсарлаж, хамгаалах, хөгжих, бүтээлч, боловсролтой, соёлтой иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтууд

4.1 Хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

4.1.1. Залуучуудын эрх бүх түвшинд хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.2. Боловсролыг чанартай, хүртээмжтэй байлгах;

4.1.3. Залуучуудын онцлог, хэрэгцээнд нийцсэн, чанартай эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох;

4.1.4. Залуучуудын хөдөлмөрийн таатай нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.5. Залуучуудын орон байрны хэрэгцээг хангах төрөл бүрийн шийдлүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;

- 4.1.6. Нийгэм дэх залуучуудын эерэг дүр төрхийг бий болгох;
- 4.1.7. Залуучуудын оролцоог дэмжих механизмыг бий болгох;
- 4.1.8. Нийгмийн дэмжлэг хэрэгтэй залуучуудад зохистой арга, хэлбэрээр хүрч ажиллах;
- 4.1.9. Залуучуудын байгууллага, залуучууд судлалыг тууштай хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

Тав. Залуучуудын эрх бүх түвшинд хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Залуучуудад эрх зүйн боловсрол олгох, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг залуучуудын орчин нөхцөлд тохирсон арга, хэлбэрээр хүргэх¹⁸, эрх зүйн боловсролыг залуучуудад төдийгүй залуучуудын ажил хариуцсан бүх түвшний төрийн албан хаагч нарт системтэйгээр олгох ажлыг Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллагууд, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

5.2. Залуучуудын эрхийн үнэлэмжийг дээшлүүлэх, бусдыг үндэс угсаа, шашин шүтлэг, арьс өнгө, хүйс, эд хөрөнгө, эрүүл мэндийн байдал зэргээр нь үл ялгаварлах, бусдын нэр төр, эрхийг хүндэтгэх үзлийг залуучуудын дунд нэмэгдүүлэх талаар залуучуудад сургалт, сурталчилгааг зохион байгуулах ажлыг Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллагууд, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

5.3. Залуучуудын эрхэмсэг оршихуйг хүндэтгэсэн залуучуудтай харилцах харилцааны стандарт бий болгох ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

5.4. Нийгэм, соёл, улс төр, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцох жендерийн тэгш эрхийг бий болгох, дэмжих чиглэлээр тусгайлан үйл ажиллагаа явуулах ажлыг Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллагууд, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

5.5. Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэрэг болон гэр бүлийн болон ажлын байран дахь бүх төрлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, өртсөн залуучуудын эрхийг хамгаалах, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн эмчилгээнд хамруулж, эрх зүйн зөвлөгөө өгөх цаашид хэвийн суралцах, ажиллах нөхцөлийг хангах нэгдсэн цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, энэ төрлийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах ажлыг Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох төрийн байгууллага, олон улсын байгууллага төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллана.

¹⁸ “Залуучуудын үндэсний бодлогыг боловсруулах чиглэлээр телевизийн болон радио нэвтрүүлгээр дамжуулан явуулсан хэлэлцүүлгийн материалд хийсэн дүн шинжилгээ” 23-24 дэх тал, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, УБ., 2014 он

5.6. Залуучуудыг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг бууруулах үүднээс энэ талаар зохистой мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах, бусад шаардлагатай арга хэмжээг залуучуудын орчин нөхцөлд тохирсон арга, хэлбэрээр хүргэх ажлыг Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох төрийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай нягт уялдаа холбоотой хамтарч ажиллана.

5.7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан торгуулийн орлогын санг залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах, хорих ангид буй эрх чөлөөгөө хязгаарлуулсан залуучуудад чиглэсэн шинэлэг радио хөтөлбөрүүдэд зориулах¹⁹ асуудлыг Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

5.8. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл бүрт залуучуудын эрхийг хамгаалах, залуучууд эрхээ эдлэх боломжийг бүрдүүлсэн механизмыг бий болгоно. Энэ үйл ажиллагааг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиглэлээр холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

Зургаа. Боловсролыг чанартай, хүртээмжтэй байлгах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.1. Ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулийн боловсролын чанар стандарт, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, сургалтын менежментэд өөрчлөлт хийх, олон улсын жишигт нийцүүлэх, мэргэжлийн ур чадвар сайтай багш нарыг бэлтгэх замаар боловсролын чанарыг сайжруулах үйл ажиллагааг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиглэлээр холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтарч ажиллана.

6.2. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт дараах хичээлийн хөтөлбөрийг нэмж тусгах, тухайн чиглэлээр мэргэшсэн сургагч багшийг бэлтгэх, оюутан сурагч, багш нар, сургуулийн удирдлагуудыг энэ төрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх, тэдний санал санаачилгыг дэмжих замаар Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.2.1. ерөнхий боловсролын сургуулийн ахлах дунд ангийн хичээлийн хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлийн хичээлийг хөтөлбөрийн үр

¹⁹ “Залуучуудын үндэсний бодлогыг боловсруулах чиглэлээр телевизийн болон радио нэвтрүүлгээр дамжуулан явуулсан хэлэлцүүлгийн материалд хийсэн дүн шинжилгээ” 14 дэх тал, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, УБ., 2014 он

нөлөөнд үнэлгээ хийх, боловсронгуй болгох арга хэмжээг сурагчид, багш нар болон эцэг эхийн оролцоотойгоор хэрэгжүүлэх;

6.2.2. ерөнхий боловсролын сургууль, их, дээд, сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдад зориулсан, ёс зүй, эрх зүйн чиглэлээр зөв боловсрол, мэдлэг олгох хичээлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

6.2.3. ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт аюултай орчин нөхцөл, байгалийн болон бусад гамшиг тохиолдоход өөртөө болон бусдад туслах, туслалцаа үзүүлэх сэдвийг тусгах;

6.2.4 их, дээд сургууль, коллежийн төгсөх ангийн оюутнуудад гэр бүлийн үнэ цэнэ, үүрэг хариуцлагын талаар ойлголт өгөх хичээлийг сургалтын хөтөлбөрт оруулах;

6.3. Бүх шатны сургуулийн суурь зорилтыг залуучуудад Монголын нийгмийн үнэт зүйлсийн баримжаа, ёс зүйн төлөвшил, иргэний боловсрол олгох, мэргэжлийн болон техникийн чиг баримжаа олж авах, авъяасаа нээн хөгжүүлэх, эрүүл мэндийн суурь боловсрол олж авахад чиглүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар төрийн байгууллага, төрийн бус байгууллага олон улсын байгууллагатай хамтарч ажиллана.

6.4. Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэг болох хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, ядуу, өнчин, орон гэргүй хүүхэд, насанд хүрээгүй хөдөлмөр эрхлэгчид, насанд хүрээгүй ээжүүдийг сурах боломжийг бүрдүүлэх, хоцрогдлыг арилгахтай холбоотой шаардлагатай арга хэмжээг авах ажлыг Хүн амын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтарч хэрэгжүүлнэ.

6.5. Хот, хөдөө орон нутаг дахь ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарын ялгааг арилгах, магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулийн, сурах орчин нөхцөлийг сайжруулах, сургалтын чанар стандартад хяналт тавих механизмыг боловсронгуй болгох ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.

6.6. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бусад залуучуудтай хамт, ижил гараанаас сурч, боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлэх үүднээс дараах арга хэмжээг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хариуцах ба энэ чиг үүргээ төрийн байгууллага, төрийн бус байгууллага, сургуулийн удирдлага, багш, эмч нар болон бусад холбогдох этгээдтэй хамтран хэрэгжүүлэх, тэдний санал санаачилгыг дэмжих, хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах зохицуулалтын механизмыг бүрдүүлэх замаар дараах арга хэмжээг авна:

6.6.1. бүх шатны сургуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сурч боловсрох нөхцөлийг хангах үүднээс тэдэнд сургуульд орох, гарах, шаардлагатай анги танхимд очих, хичээлээ ойлгоход нь туслах зорилго бүхий туслах үйлчилгээг нэвтрүүлэх,

хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр боловсролын байгууллагуудыг хангах;

6.6.2. сургалтын материал, сурах бичиг, гарын авлагыг брайль хэл дээр боловсруулах, хэвлэх;

6.6.3. хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бэрхшээл болгоны онцлогоос хамаарч, холбогдох багш, сурган хүмүүжүүлэгч, туслах үйлчилгээ үзүүлэгчдийг бэлтгэн гаргах, тэднийг боловсролын байгууллагуудад ажиллах бололцоог хангах;

6.7. Их, дээд сургуулийн суралцагч нь үндсэн мэргэжил ба дэд мэргэжил гэсэн хос мэргэжлээр суралцах боломжийг бүрдүүлэх ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар төрийн байгууллага, төрийн бус байгууллага олон улсын байгууллагатай хамтарч ажиллана.

6.8. Их, дээд сургуулиуд ба төгсөгчдийн хоорондын эргэх холбоог хангуулах, төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлд байршиж буй үзүүлэлтийг бодитойгоор тооцсон, шударга шалгуур бүхий хөндлөнгийн рейтингийн системийг нэвтрүүлэх ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтарч ажиллана.

6.9 Оюутан залуучуудад цагаа зөв зохистой өнгөрүүлэх боломж олгох үүднээс их дээд сургуулийн дэргэд урлаг, спортын дугуйлан хичээллүүлэхийг дэмжих, бүх нийтийн номын сангийн чанар хүртээмжийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг авах ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиглэлээр холбогдох бусад төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

6.10. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын чанарыг сайжруулах, оюутан залуучуудыг төгсөөд ажил эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байраар хангах боломжийг бүрдүүлэх ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

6.11. Хичээл сургуульдаа тодорхой амжилт гаргасан, үе тэнгийнхнийгээ эрдэм ном авьяас чадвараараа тэргүүлж буй залуучуудыг гадаадын төдийгүй дотоодын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг тусалцаа үзүүлэх, бусад тэтгэлэгт хөтөлбөрөөс ялгагдах онцлог бүхий үндэсний хэмжээний тэтгэлэгт хөтөлбөр бий болгох, жил бүр зохион байгуулах ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

6.12. Мэргэжлээрээ үр бүтээлтэй, амжилттай ажиллаж байгаа болон гоц авьяастай оюуны өндөр чадвартай өсвөр үе залуучуудын оюуны бүтээл хөдөлмөр, бодит санал санаачилгыг нь дэмжих, санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ

холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

6.13. Их дээд сургуулийн залуу багш, оюутны шилдэг бүтээлийг олон нийтэд таниулах, судалгаа шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх, мэдлэг бизнесийн түншлэл бүтээлч хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго бүхий залуу багш, оюутны үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний бага хурлыг дэмжих, тэндээс гарсан бодит санал санаачилгыг хэрэгжүүлэхийг дэмжих, санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

6.14. Түүх соёл, нийгэм эдийн засаг, ёс заншил, хүний хөгжил, бүтээн байгуулалт, шинэ содон мэдээллийг түгээх, залуучуудын боловсролд хөрөнгө оруулах, зөв хувь хүн болгон төлөвшүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой сургалт, сурталчилгааны арга хэмжээг дэмжих, энэ төрлийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

6.15. Орчин үеийн техник, технологийг ашигласан онлайн сургалтын системд хамрагдан боловсрол эзэмших нөхцөлөөр залуучуудыг хангах ажлыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Долоо. Залуучуудын онцлог, хэрэгцээнд нийцсэн, чанартай эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

7.1. Залуучуудад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ, мэргэшсэн хүний нөөцийг хөгжлийн талаар тухайлсан салбарын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах энэ талаар холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

7.2. Залуучуудын дунд эрүүл амьдралын хэв маягийг бүрдүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, зарим өвчний хор нөлөөг таниулах чиглэлээр нөлөөллийн болон сургалтын ажлуудыг зохион байгуулах сургалт хийх сурталчлах, эрүүл мэндийн тодорхой асуудлаар холбогдох зөвлөгөө өгөх боломж бүхий төвүүдийг хот, хөдөө орон нутагт байгуулах ажлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

7.3. Залуучуудын дундах архи тамхи болон бусад хорт зуршлын хэрэгцээг бууруулах, хорт зуршил, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, эрүүл зохистой хооллолтыг дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сургууль, гэр бүл, байгууллага хамт олны хүрээнд зохион байгуулах ажлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ

талаар үүргээ холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

7.4. Эрүүл мэндийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, ДОХ/БЗДХ, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтуудыг, зохион байгуулах өргөжүүлэх, тогтмолжуулах ажлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

7.5. Залуучуудад үе тэнгийнхнээр дамжуулан эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн боловсрол олгогчдын ур чадварыг дээшлүүлэх, шинэлэг арга барил эзэмшүүлэх талаар олон улсын туршлага судлах тэдэнтэй хамтарч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

7.6. Залуучуудад илүү өртдөг өвчин эмгэгийн талаар төрөл бүрийн зөвлөгөө өгөх, шинжилгээ хийх төвүүдийг нэмэгдүүлж залуучууд жилд нэг удаа үнэгүй шинжилгээ, оношилгоонд хамрагдах боломжоор хангах ажлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

7.7. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бэрхшээлийг тогтоох, түүнд нь тохирсон нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэл зүйн эмчилгээ хийх олон улсын туршлагыг судлах замаар энэ төрлийн тусгайлсан эмчилгээг улсын эмнэлгүүдэд нэвтрүүлэх ажлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

7.8. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй, үр дүнтэй, хүртээмжтэй болгох ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

7.9. Гэр бүлийн болон сургууль, ажлын байранд үүсэж болох төрөл бүрийн сэтгэл гутрал, хямралын эсрэг сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмчилгээ хийх боломж бүхий тогтмол үйл ажиллагаа бүхий төвийг байгуулах ажлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

7.10. Бүх нийтийн биеийн тамир, спортын хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх, хүрээг тэлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, залуучуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх боломж бүхий үйлчилгээний төвүүдийг бий болгох, цэцэрлэгт хүрээлэн барих, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, импортлоход татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бий болгох ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Найм. Залуучуудын хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлэх
зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

8.1. Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж, хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй мэргэжилтэн бэлтгэх ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар их, дээд сургуулиудтай хамтарч ажиллана.

8.2. Залуучуудыг мэргэжлээ сонгох явцад мэргэжлийн талаар ойлголт өгөх, мэргэжил сонгох зөвлөгөө өгөх, хамгийн хэрэгцээтэй байгаа ажлын байрны талаар жагсаалт гарган сурталчлах, үзэсгэлэн яармаг зохион байгуулах ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар төрийн байгууллага болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллана.

8.3. Хөдөлмөрийн үнэлэмжийг өөрчлөх, хийж бүтээснээр нь үнэлдэг болох, суралцахын хажуугаар цагаар ажиллан хөлсийг өдөрт нь олгодог ажлын байр бий болгох, энэ талаар ажил олгогч байгууллагын санал санаачилгыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дэмжиж хамтарч ажиллана.

8.4. Залуучуудыг ажлын байраар хангах, эзэмшсэн мэргэжлийнх нь хүрээнд дадлагажуулах боломжийг бүрдүүлэх ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар төрийн байгууллага, төрийн бус байгууллагатай хамтарч ажиллана.

8.5. Дээд боловсролтой, ахисан түвшний судалгааны ажил эрхэлж байгаа залуу хүмүүст зориулсан цагийн ажлыг бий болгох үүднээс төрийн албанд судалгаа, шинжилгээний чиглэлийн цагийн ажлын квотыг их, дээд сургуулийн докторантурын хөтөлбөрүүдтэй харилцан уялдаатайгаар бий болгох ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

8.6. Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэг болох хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, нэн ядуу, өнчин, орон гэргүй, хараа хяналтгүй хүүхэд, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт байгаа хүүхдүүд, өрх толгойлсон залуу эцэг, эх, хорих ангид хоригдож буй залуучуудыг ажлын байраар хангах, тэдэнд хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлэх ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хариуцах ба энэ талаар холбогдох бусад төрийн байгууллагатай, төрийн бус байгууллага, олон байгууллагатай хамтарч ажиллана.

8.7. Их, дээд сургууль, төгсөгчдийг сургуулиа төгссөний дараа орон нутагт сэтгэл хангалуун ажиллах амьдрах боломжийг бүрдүүлэх ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар аймаг, сумын Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага холбогдох бусад төрийн байгууллагатай хамтарч ажиллана.

8.8. Аж үйлдвэржилт, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх замаар хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрны тоог нэмэгдүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулах талын ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар холбогдох бусад төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

8.9. Залуучуудад бизнес эрхлэх, амьдрал ахуйгаа дээшлүүлэх нөхцөл боломжийг судалж бүрдүүлэх, бизнес эрхлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

8.10. Гадаадад боловсрол эзэмшсэн, өндөр ур чадвар бүхий залуучуудыг эх орондоо сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, шинэ ажлын байр бий болгох ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулах ба энэ талаар бусад төрийн байгууллагатай хамтарч ажиллана.

8.11. Анх ажилд орж байгаа залуучуудад ажил олгогчийн зүгээс тавьдаг босго шаардлагыг багасгах, тэднийг дэмжих талаар Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

8.12. Залуучуудын ажлын байран дахь хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах ажлыг олон улсын стандарт, туршлагын дагуу удирдлага, арга зүйгээр хангаж, ажлын байрны нөхцөл, аюулгүйн техник, хувцас, хэрэгсэл, тоноглолоор хангагдах эрхийг бодитой бий болгох ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтарч ажиллана.

8.13. Гадаадад ажил, хөдөлмөр эрхэлж байгаа залуучуудын нийгмийн даатгал, хамгааллын үйлчилгээнд хамрагдах асуудлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

Ес. Залуучуудын орон байрны хэрэгцээг хангах төрөл бүрийн шийдлүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

9.1. Залуучуудын орон байрын хэрэгцээг хангах зорилгоор хот болон хөдөө орон нутагт залуучууд болон залуу гэр бүлд зориулсан хямд үнэ бүхий чанартай орон байр, орон сууцны хорооллуудыг шинээр барихад аж ахуйн нэгжүүдэд бодит хөшүүрэг бий болгох, хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хариуцах ба энэ чиглэлээр холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

9.2. Залуучууд болон залуу гэр бүлд хувийн орон байртай болох боломжийг бий болгох үүднээс урьдчилгаа төлбөргүйгээр, бага хүүтэй, урт хугацааны зээлд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлэх энэ талаар шаардлагатай арга хэмжээг авах ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиглэлээр холбогдох бусад төрийн байгууллагатай хамтарч ажиллана.

9.3. Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагын удирдлагын зүгээс залуу ажилтнуудаа хямд өртөг бүхий чанартай орон байртай болгох төслийг амжилттай хэрэгжүүлсэн байгууллага болон энэ төрлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй байгууллагуудад туршлага солилцох боломж олгох үүднээс холбогдох өдөрлөгийг тогтмол хугацаанд зохион байгуулах, байгууллагуудыг мэдээ мэдээллээр хангах ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиглэлээр холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

9.4. Орон байр худалдан авах боломжгүй залуу гэр бүл, нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэгт зориулж хямд үнэ, бүрэн тоноглол, бүрэн тавилга, үйлчилгээ бүхий хөлсний болон нийтийн байрууд барих зорилт дэвшүүлж төр, хувийн хэвшлийн хамтын түншлэл байгуулах болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хариуцах ба энэ чиглэлээр холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

9.5. Алслагдсан сум сууринд мэргэжилтэй залуу боловсон хүчин ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс орон байртай болоход хөнгөлөлт үзүүлэх, үүнээс гадна хүүхдийн цэцэрлэг, сургууль эмнэлгийг бий болгох ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хариуцах ба энэ чиглэлээр холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

9.6. Хот хөдөө орон нутагт оюутан залуучуудын сурч, амьдрах нөхцөлийг орчин нөхцөлийг хангахуйц оюутны дотуур байр шинээр нэмж барих, одоо байгаа оюутны дотуур байруудын орчин нөхцөлийг сайжруулах үйл ажиллагааг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиглэлээр холбогдох бусад төрийн байгууллагатай хамтарч ажиллана.

9.7. Орон гэргүй, нэн ядуу, архи согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх бодис донтсон зэрэг нийгмийн дэмжлэг шаардлагатай залуучуудад сэтгэл засал, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ, хордлого тайлах, хооллох зэрэг үйлчилгээ бүхий тусгай зориулалтын байруудыг барьж байгуулах, үйлчилгээг нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр шийдвэрлэх асуудлыг олон улсын туршлага, олон улсын байгууллагуудын тусламж, зөвлөгөөнд тулгуурлан бий болгох ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

9.8. Залуучууд, залуу гэр бүлд хямд өртөг бүхий орон сууц худалдан авах, хөлслөхөд зориулж төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар тогтмол мэдээ, мэдээлэл өгөх ажлыг Барилга хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох нэгжээрээ дамжуулан хэрэгжүүлнэ.

Арав. Нийгэм дэх залуучуудын эерэг дүр төрхийг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

10.1. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй контентыг залуучуудад зөв, хүмүүжил төлөвшил бий болгоход түлхүү чиглүүлж, залуучуудын талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээ мэдээллийг түгээхээс татгалзах талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүнийг төлөөлөх байгууллагуудтай зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Энэ үйл ажиллагааг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар холбоо харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үндэсний хэмжээний төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

10.2. Олон улсад болон дотоодод мэргэжлийн ур чадвар, манлайлал, ёс суртахуун зэргээр үлгэж жишээ болж, амжилт гаргасан залуучуудын манлайллыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлах, олонд түгээх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ талаар холбоо харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үндэсний хэмжээний төрийн бус байгууллагатай болон холбогдох бусад төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

10.3. Монгол залуучуудын ухаалаг, орчин нөхцөлд хурдан зохицож, хөрвөх чадвар сайтай, тусархаг гэх Монгол залуу хүний эерэг дүр төрхийг дотоодод болон олон улсын түвшинд бий болгох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлах таниулах ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, холбоо харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцах ба энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн үндэсний хэмжээний төрийн бус байгууллагатай болон холбогдох бусад төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Арван нэг. Залуучуудын оролцоог дэмжих механизмыг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

11.1. Залуучуудыг нийгэм, соёл, улс төрийн асуудлаар өөрсдийн дуу хоолойг хүргэх, шийдвэр гаргах түвшинд оролцох боломжоор хангах, тэдний бодит санал санаачилгыг дэмжих замаар оролцоог хангах механизмыг бүрдүүлэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

11.2. Залуучуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулах, залуучуудын сонгуулийн идэвх оролцоог сайжруулах талаар судалгаа хийж, үр дүнд хүргэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Сонгуулийн асуудал хариуцсан төрийн байгууллагатай хариуцах ба энэ чиг үүргээ бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

11.3. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас санаачилсан залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, сайжруулах үр дүн бүхий төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгох ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

11.4. Залуучуудын авьяас чадварыг дэмжин, соёл урлаг, спортын арга хэмжээнд оролцох, түүх, соёл, уламжлалт зан заншлаа хамгаалан хөгжүүлэхэд оролцох боломжийг нэмэгдүүлэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

11.5. Оюутнуудын нийгмийн оролцоог идэвхжүүлэх, дэмжих үүднээс тэдний хийж буй нийгмийн сайн сайхны төлөөх сайн дурын ажлыг кредитжүүлэх кредитийн системийг бий болгоно. Энэ үйл ажиллагааг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хариуцаж хэрэгжүүлнэ.

11.6. Оюутны байгууллагад тодорхой асуудлаар төсөв хөрөнгийн эрх мэдэл олгох хариуцлагажуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.

11.7. Сургууль хамт олны орчинд комьюнити радио, сонин хэвлэлийг залуучуудын санал, санаачилга, оролцоотойгоор бий болгох уг үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагааг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

11.8. Залуучуудыг улс орон, нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс улс төрийн оролцоог дэмжих, сонгуульд идэвхтэй санал өгдөг болгох механизмыг бүрдүүлэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Арван хоёр. Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэгт зохистой арга, хэлбэрээр хүрч ажиллах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

12.1. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бэрхшээл болгоны онцлогоос хамаарч албан ёсны ангиллыг батлах ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

12.2. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын нийгэмд ажиллаж амьдрах дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд зорчих зам талбай

олон нийтийн газар, нийтийн тээврийн хэрэгсэл, нийтийн бие засах газрыг хэвийн хэрэглээний шаардлагыг хангах түвшинд хүргэх холбогдох стандартыг батална. Энэ үйл ажиллагааг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ стандартын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон холбогдох төрийн захиргааны бүх байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

12.3. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад нийгмийн өдөр тутмын амьдралд оролцоход нь туслах зорилго бүхий туслах үйлчилгээг бий болгох, туслах үйлчилгээ үзүүлэгчдийг бэлтгэх албан ёсны сургалт зохион байгуулах, сургууль, албан байгууллагад туслах үйлчилгээ үзүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх, туслах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх туслах үйлчилгээний зардлыг батлах ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

12.4. Их дээд сургуульд тэнцсэн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сургалтын төлбөрийг бүрэн хэмжээнд олгох ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

12.5. Залуучуудыг сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад чиглүүлэх ажлыг энэ хөтөлбөрийн 11 дүгээр зүйлийн 11.5-д заасны дагуу Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам шийдвэрлэнэ.

12.6. Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэг болох хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт байгаа хүүхдүүд болон гэр оронгүй, бүтэн өнчин, асран хамгаалах хүнгүй хүүхдүүд, асрамжийн газраас гарч буй залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, архи, мансуурах болон сэтгэцэд нөлөөлөх эм бодисонд донтсон залуучуудад зориулсан тусгайлсан үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг дэмжинэ. Энэ ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох төрийн байгууллага, олон улсын байгууллагуудтай нягт хамтарч ажиллана.

12.7. Хорих ял эдэлж байгаа залуучуудад иргэний болон эрх зүйн боловсрол олгох, сэтгэл зүйн мэргэжлийн тусгай радио хөтөлбөрийг бий болгох²⁰ ажлыг Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Хүн амын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба төрийн бус байгууллагатай энэ чиглэлээр хамтарч ажиллана.

12.8. Хорих ял эдэлж буй залуучуудад боловсрол мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед үргэлжлүүлэн сурах, ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг Хууль зүйн асуудал төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын асуудал

²⁰ “Залуучуудын үндэсний бодлогыг боловсруулах чиглэлээр телевизийн болон радио нэвтрүүлгээр дамжуулан явуулсан хэлэлцүүлгийн материалд хийсэн дүн шинжилгээ” 14 дэх тал, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, УБ., 2014 он

хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Арван гурав. Залуучуудын байгууллага, залуучууд судлалыг тууштай хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

13.1. Залуучуудад тулгарч буй асуудлыг нийгмийн салбар бүрээр тодорхойлох, төрөөс залуучуудад чиглэсэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд хяналт үнэлгээ хийх аргачлалыг сайжруулах зорилгоор залуучуудад чиглэсэн үндэсний хэмжээний судалгаа болон бусад судалгааг хийх, тогтмол тайлан гаргах, залуучууд судлалыг хөгжүүлэх механизмыг бүрдүүлнэ. Энэ үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг хангах асуудлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

13.2. Залуучуудад чиглэсэн судалгааны ажлыг нээлттэй, ил тод сонгон шалгаруулалт зарлаж залуучуудын асуудлаар мэргэшсэн төрийн бус байгууллага, судлаачдын багаар гэрээний үндсэн дээр хийлгэнэ. Энэ үйл ажиллагааг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

13.3. Залуучуудад чиглэсэн бодлогын болон академик түвшний судалгаанд зориулсан тэтгэлэгт хөтөлбөрийг жил бүр зохион байгуулах ажлын Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

13.4. Залуучуудад чиглэсэн судалгаа хийх мэргэжилтэн, төрийн бус байгууллагыг нэмэгдүүлэх, судалгааны арга зүйг сайжруулах, судалгаанаас гарсан үр дүнг үнэлэх, хэрэгжүүлэх арга механизмыг бүрдүүлэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

13.5. Залуучуудад чиглэсэн судалгааны сэдвийг тодорхойлох, нарийвчлах, судалгааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, өмнөх жилийн судалгааны үр дүнгийн биелэлтийн талаар дүгнэх зорилгоор төрийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, залуучуудын асуудлаар дагнасан судалгаа явуулдаг судлаачид, залуучуудын төлөөллийг оролцуулсан зөвлөлдөх уулзалтыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага жил бүр зохион байгуулна.

13.6. Залуучуудын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, тухайн байгууллагуудын мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах, хамтарч залуучууд руу чиглэсэн төрөл бүрийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтарч хэрэгжүүлнэ.

13.7. Хөтөлбөрийн хяналт үнэлгээг залуучуудын байгууллагаар дамжуулан гэрээний үндсэн хийлгэх механизмыг бүрдүүлэх ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах ба энэ чиг үүргээ холбогдох төрийн

байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

13.8. Залуучуудын хөгжлийн талаарх төрөөс баримтлах бодлого, “Монгол залуу хүн” үндэсний хөтөлбөр болон бусад залуучуудад чиглэсэн төсөл хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, залуучууд руу чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын талаарх мэдээлэл, залуучуудад чиглэсэн улсын хэмжээний томоохон арга хэмжээ, судалгааны тайлан, төсөв хөрөнгийн талаарх мэдээ, мэдээллийг залуучуудад нээлттэй хүргэх үүднээс үндэсний хэмжээний портал сайт ажиллуулна. Энэ үйл ажиллагааг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах бөгөөд холбогдох төрийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллана.

Арван дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохицуулалт,
оролцогч талуудын үүрэг оролцоо

14.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох бүх байгууллага, иргэдийн оролцоог хангах, хөрөнгийг үр ашигтай зарцуулах, иргэний нийгмийн зүгээс тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах, төр, иргэний нийгэм, аж ахуйн нэгж, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хандивлагчдын дэмжлэгийг өргөжүүлэх механизмыг бүрдүүлнэ.

14.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг салбар дундын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилт, төсөв хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, үр дүнд үнэлгээ хийлгэх зэрэг чиг үүргийг Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх Залуучуудын Бодлогын Үндэсний Хороо (цаашид Үндэсний хороо гэх) хэрэгжүүлнэ. Үндэсний хорооны дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд байх ба аймаг, нийслэлд Засаг даргаар ахлуулсан салбар хороо байгуулж ажиллуулна.

14.3. Үндэсний болон салбар хорооны бүрэлдэхүүнд иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг заавал оруулна.

14.4. Хорооны ажлын албаны үүргийг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

14.5. Ажлын алба дараах үүрэгтэй:

14.5.1. хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах;

14.5.2. шаардлагатай төсөв, хөрөнгийн тооцоог хийж, холбогдох байгууллагад тавьж, шийдвэрлүүлэх;

14.5.3 Үндэсний хорооны хурлыг зохион байгуулах, холбогдох шийдвэрийн төслийг бэлтгэх, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

14.5.4. хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бусад төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах, тэдний санал санаачилгыг дэмжих, нягт уялдаа холбоотой хамтарч ажиллах.

14.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүргийг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

14.7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

14.7.1. Бүх шатны Засаг дарга:

а) нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд залуучуудын амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг тодорхойлох судалгаанд хамруулж мэдээллийн сан бүрдүүлэх;

б) нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийгмийн дэмжлэг шаардлагатай залуучуудын талаарх судалгааг гаргаж хариуцсан төрийн захиргааны байгууллагыг болон дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;

в) нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд залуучуудын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан нутгийн өөрөө удирдах байгууллагаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

г) нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд залуучуудын хэрэгцээ шаардлагын талаар судалгааг төрийн бус байгууллагуудтай гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;

д) нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа залуучуудад чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллах;

е) нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа залуучуудад чиглэсэн бодлого, хөтөлбөр арга хэмжээнд хамрагдсан залуучуудын судалгааг гарган хариуцсан төрийн захиргааны байгууллагыг болон дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;

14.7.2. Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

а) хөтөлбөрийг хэрэгжүүлэх төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;

б) хөтөлбөрийн талаарх мэдээ мэдээллийг Үндэсний хороо болон бусад этгээдүүдэд тогтмол өгч байх;

в) хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн ерөнхий тайланг жил бүр гаргаж, нийтэд ил тод мэдээлэх;

14.7.3. Төрийн захиргааны төв байгууллага:

а) хөтөлбөрт тусгагдсан ажлыг салбарын бодлого төлөвлөгөөндөө тусгах хэрэгжүүлэх;

б) төсөл, хөтөлбөр боловсруулах замаар олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хандивын байгууллага, төр хувийн хэвшлийн хамтын түншлэлээс хөрөнгө босгох ажлыг зохион байгуулах;

в) хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах, түүний үр дүнгийн талаар нэгдсэн тайлан гаргаж ажлын албанд тогтмол мэдээлэх;

14.7.4. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага:

- а) залуучуудын талаар судалгаа хийх, тайлан гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх;
- б) хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх ажлыг гэрээгээр гүйцэтгэх;

Арван тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах,
хяналт, үнэлгээ хийх

15.1. Төрийн захиргааны төв байгууллагууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагууд нь жил бүрийн 1 дүгээр сард багтаан хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж тайланг нэгтгэнэ.

15.2. Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн нэгдсэн тайланд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг Засгийн газар, Үндэсний хороонд жил бүр танилцуулна.

15.3. Залуучуудын хөгжлийн асуудлаар мэргэшсэн судалгааны байгууллага, багаар гэрээний үндсэн дээр хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэж болно.

Арван зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн

16.1. “Монгол залуу хүн” үндэсний хөтөлбөр нь 2015 оноос 2024 он хүртэл нийт 10 жилийн хугацаанд дараах үе шаттайгаар хэрэгжинэ.

16.1.1. I үе шат: 2015-2019 он

16.1.2. II үе шат: 2020-2024 он

16.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, 2015 оны тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ.

№	Хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилтууд болон голлох шалгуур үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин	
			2015 он	2015-2019 он
Зорилт 1. Залуучуудын эрх бүх түвшинд хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх				
1.	Залуучуудын гэмт хэргийн түвшин (15-29 насны хооронд)			

2.	Залуучуудын жөндөрийн тэгш бус байдлын индекс ²¹ (15-29 насны хооронд)			
3.	Залуучуудын тэгш бус байдлын нөлөөллийг тооцсон Хүний хөгжлийн индекс ²² (15-29 насны хооронд)			
Зорилт 2. Боловсролыг чанартай хүртээмжтэй байлгах				
1.	Сургуулийн насны хүүхдүүдийн сургууль завсардалтын түвшин (15-18 насны хооронд)			
2.	Ерөнхий боловсролын 1 сургуульд ногдох сурагчдын тоо			
3.	Их, дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин			
Зорилт 3.Залуучуудын онцлог хэрэгцээнд нийцсэн, чанартай эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох				
1.	Залуучуудын дундах нас баралтын түвшин (15-29 насны хооронд)			
2.	Залуучуудын дундах халдварт бус өвчний түвшин ²³			
3.	Залуучуудын өвчний эрсдэлт хүчин			

²¹ ЖТББИ-ийг тооцохын тулд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүд (эхийн эндэгдэлийн коэффициент, өсвөр үеийнхний төрөлтийн коэффициент), эрх мэдлийн үзүүлэлт (УИХ дахь эмэгтэй эрэгтэй гишүүдийн тооны харьцаа), хөдөлмөрийн зах зээл (Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцоо) зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэнэ. “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн хоёрдугаар бүлэг, нэгдүгээр хэсэг, 25 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

²² Тэгш бус байдлын нөлөөллийг тооцсон Хүний хөгжлийн индекс нь тэгш бус байдлын нөлөөллөөс болж ХХИ хэрхэн өөрчлөгдөж байгааг илэрхийлэх бөгөөд “индекс бүрийг тэгш бус байдлын нөлөөлөлтэй уялдуулан тооцох замаар ХХИ-ийн гурван бүрэлдэхүүн үзүүлэлтийг нарийвчлан тооцоолон гаргадаг. “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн хоёрдугаар бүлэг, нэгдүгээр хэсэг, 22 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

²³ “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн гуравдугаар бүлэг, хоёрдугаар хэсэг, 3-5 дахь тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

	зүйлсийн түвшин ²⁴			
Зорилт 4. Залуучуудын хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлэх				
1.	Бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой залуучуудын ажилгүйдлийн түвшин			
2.	Тусгай дунд боловсролтой залуучуудын ажилгүйдлийн түвшин			
3.	Дээд боловсролтой залуучуудын ажилгүйдлийн түвшин			
4.	Хөдөө, орон нутаг дахь залуучуудын ажилгүйдлийн түвшин			
5.	Хот, суурин газар дахь залуучуудын ажилгүйдлийн түвшин			
6.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих багц үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан залуучуудын тоо			
7.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний түвшин (15-29 насны хооронд)			
8.	Хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тоо (15-17 насны хооронд)			
Зорилт 5. Залуучуудын орон байрны хэрэгцээг хангах төрөл бүрийн шийдлүүдийг бий болгох				
1.	Орон сууцны ипотекийн зээл авсан залуучуудын тоо			
2.	Залуучуудад зориулсан хямд үнэ бүхий орон сууцны тоо			
3.	Зориулалтын дотуур байранд			

²⁴ Өвчний эрсдэлт хүчин зүйлст эрүүл бус хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээ гэх мэт багтдаг байна. “Хүний хөгжлийн илтгэл” 2014 эхний төслийн хоёрдугаар бүлэг, нэгдүгээр хэсэг, 6 дэх тал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, УБ., 2014 он

	хамрагдаж буй оюутны тоо			
4.	Зорилтод бүлэгт зориулсан хямд үнэ бүхий түрээсийн орон сууцны (хөлсний болон нийтийн) тоо			
5.	Зорилтод бүлэгт зориулсан хямд үнэ бүхий түрээсийн орон сууц (хөлсний болон нийтийн)-нд хамрагдсан залуучуудын тоо			
Зорилт 6. Залуучуудын оролцоог дэмжих механизмыг бий болгох				
1.	Улсын болон аймаг, нийслэл сум, дүүргийн хэмжээний бодлого боловсруулалт, шийдвэр гаргалтанд оролцсон залуучуудын тоо			
2.	Төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд оролцсон залуучуудын тоо (аймаг, нийслэл, сум дүүргээр гаргана)			
3.	Залуучуудын сонгуулийн ирц (өмнөх сонгуулиудтай харьцуулсан үзүүлэлтээр гаргана)			
Зорилт 7. Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэгт зохистой арга, хэлбэрээр хүрч ажиллах				
1.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сургуульд хамрагдалтын түвшин			
2.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн түвшин			
3.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих багц үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын тоо			
4.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн			

	үйлчилгээнд хамрагдсан залуучуудын тоо (давхардсан тоогоор)			
5.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж буй аймаг, сум, дүүргийн тоо			
6.	Хорихоос суллагдсан залуучуудын дахин гэмт хэрэг үйлдэлтийн бууралтын түвшин			
7.	Хорих байгууллагад хэрэгжүүлсэн сэтгэл зүйн болон иргэний боловсрол олгох зорилго бүхий радио нэвтрүүлгийг хүргэсэн хүмүүжигчдийн тоо (15-29 насны хооронд)			
8.	Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод (15-29 насны хооронд) тусламж үзүүлэх зорилго бүхий нэг цэгийн үйлчилгээний байгууллагын тоо			
Зорилт 8.Нийгэм дэх залуучуудын эерэг дүр төрхийг бий болгох				
1.	Нийгэм дэх залуучуудын эерэг дүр төрхийг бий болгох чиглэлээр зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтуудын тоо			
2.	Зөвлөлдөх уулзалтын хүрээнд хийгдсэн нийтлэл, нэвтрүүлэг, кино, клип, уран бүтээлийн тоо			
3.	Дээрх чиглэлээр үндэсний болон орон нутгийн радио телевизээр цацагдсан нэвтрүүлгийн эфирийн цаг			
Зорилт 9. Залуучуудын байгууллага, залуучууд судлалыг тууштай хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх				
	Залуучуудын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэгч төрийн байгууллага,			

1.	төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр улсын хэмжээнд болон аймаг нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо			
2.	Төрийн байгууллагаас залуучуудын байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн ажлын тоо			
3.	Төрийн байгууллагаас залуучуудын байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ			
4.	Залуучууд судлалын хүрээнд хийгдэж нийтийн хүртээл болсон судалгааны ажлын тоо			
5.	Залуучууд судлалд төрийн болон орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ			
Залуучуудад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ				
1.	Залуучуудын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ			
2.	Залуучуудын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ			
3.	Залуучуудын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ ДНБ-нд эзлэх хувиар			

Арван долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

17.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

17.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

17.1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө;

17.1.3. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээн дэх хувийн хэвшлийн хөрөнгө;

17.1.4. НҮБ-ын Хүн амын сангаас хэрэгжүүлж буй “Залуучуудын хөгжил 2013-2017” төслийн хөрөнгө;

17.1.5. Хандивлагч, олон улсын байгууллагын зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт;

17.1.6. Бусад эх үүсвэр.

17.2. Хөтөлбөрийн стратегийн зорилт, арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусган хэрэгжүүлэхээс гадна санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөрөнгө оруулалт, хандив, тусламж, төслийн хөрөнгөөс давхардал, хийдэл, алдагдалгүй, хэмнэлт, үр ашигтай зохион байгуулах замаар хэрэгжүүлнэ.

----- оОо -----

“МОНГОЛ ЗАЛУУ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр
Зорилт 1. Залуучуудын эрх бүх түвшинд хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх					
1.	Залуучуудад эрх зүйн боловсрол олгох, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг залуучуудын орчин нөхцөлд тохирсон арга, хэлбэрээр хүргэх, эрх зүйн боловсролыг залуучуудад төдийгүй залуучуудын ажил хариуцсан бүх түвшний төрийн албан хаагч нарт системтэйгээр олгоно.		Хууль зүйн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
2.	Залуучуудын эрхийн үнэлэмжийг дээшлүүлэх, бусдыг үндэс угсаа, шашин шүтлэг, арьс өнгө, хүйс, эд хөрөнгө, эрүүл мэндийн байдал зэргээр нь үл ялгаварлах, бусдын нэр төр, эрхийг хүндэтгэх үзлийг залуучуудын дунд нэмэгдүүлэх талаар залуучуудад сургалт, сурталчилгааг зохион		Хууль зүйн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

	байгуулна.				
3.	Залуучуудын эрхэмсэг оршихуйг хүндэтгэсэн залуучуудтай харилцах харилцааны стандарт бий болгоно.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	-	
4.	Нийгэм, соёл, улс төр, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцох жендерийн тэгш эрхийг бий болгох, дэмжих чиглэлээр тусгайлан үйл ажиллагаа явуулна.		Хууль зүйн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
5.	Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэрэг болон гэр бүлийн болон ажлын байран дахь бүх төрлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, өртсөн залуучуудын эрхийг хамгаалах, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн эмчилгээнд хамруулж, эрх зүйн зөвлөгөө өгөх цаашид хэвийн суралцах, ажиллах нөхцөлийг хангах нэгдсэн цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, энэ төрлийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулна.		Хууль зүйн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
6.	Залуучуудыг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг бууруулах үүднээс энэ талаар зохистой мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион		Хууль зүйн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

	байгуулах, бусад шаардлагатай арга хэмжээг залуучуудын орчин нөхцөлд тохирсон арга, хэлбэрээр хүргэнэ.				
7.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан торгуулийн орлогын санг залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах, хорих ангид буй эрх чөлөөгөө хязгаарлуулсан залуучуудад чиглэсэн шинэлэг радио хөтөлбөрүүдэд зориулна.		Хууль зүйн яам	Төрийн байгууллагууд	
8.	Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл бүрт залуучуудын эрхийг хамгаалах, залуучууд эрхээ эдлэх боломжийг бүрдүүлсэн механизмыг бий болгоно.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
Зорилт 2. Боловсролыг чанартай, хүртээмжтэй байлгах					
1.	Ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулийн боловсролын чанар стандарт, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, сургалтын менежментэд өөрчлөлт хийх, олон улсын жишигт нийцүүлэх, мэргэжлийн ур чадвар сайтай багш нарыг бэлтгэх замаар боловсролын чанарыг сайжруулна.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

2.	<p>Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт дараах хичээлийн хөтөлбөрийг нэмж тусгах, тухайн чиглэлээр мэргэшсэн сургагч багшийг бэлтгэх, оюутан сурагч, багш нар, сургуулийн удирдлагуудыг энэ төрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх, тэдний санал санаачилгыг дэмжих замаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • ерөнхий боловсролын сургуулийн ахлах дунд ангийн хичээлийн хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлийн хичээлийг хөтөлбөрийн үр нөлөөнд үнэлгээ хийх, боловсронгуй болгох арга хэмжээг сурагчид, багш нар болон эцэг эхийн оролцоотойгоор хэрэгжүүлэх; • ерөнхий боловсролын сургууль, их, дээд, сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдад зориулсан, ёс зүй, эрх зүйн чиглэлээр зөв боловсрол, мэдлэг олгох хичээлийн хөтөлбөр 		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
----	--	--	-------------------------------------	--	--

	<p>боловсруулан хэрэгжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> • ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт аюултай орчин нөхцөл, байгалийн болон бусад гамшиг тохиолдоход өөртөө болон бусдад туслах, туслалцаа үзүүлэх сэдвийг тусгах; • их, дээд сургууль, коллежийн төгсөх ангийн оюутнуудад гэр бүлийн үнэ цэнэ, үүрэг хариуцлагын талаар ойлголт өгөх хичээлийг сургалтын хөтөлбөрт оруулах; 			
3.	<p>Бүх шатны сургуулийн суурь зорилтыг залуучуудад Монголын нийгмийн үнэт зүйлсийн баримжаа, ёс зүйн төлөвшил, иргэний боловсрол олгох, мэргэжлийн болон техникийн чиг баримжаа олж авах, авъяасаа нээн хөгжүүлэх, эрүүл мэндийн суурь боловсрол олж авахад чиглүүлэх талаар холбогдох арга хэмжээ авна.</p>		<p>Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам</p>	<p>Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага</p>
4.	<p>Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэг болох хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, ядуу, өнчин, орон гэргүй хүүхэд, насанд хүрээгүй хөдөлмөр эрхлэгчид, насанд хүрээгүй ээжүүдийг сурах боломжийг бүрдүүлэх, хоцрогдлыг арилгахтай холбоотой</p>		<p>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам</p>

	шаардлагатай арга хэмжээг авна.				
5.	Хот, хөдөө орон нутаг дахь ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарын ялгааг арилгах, магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулийн, сурах орчин нөхцөлийг сайжруулах, сургалтын чанар стандартад хяналт тавих механизмыг боловсронгуй болгоно.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам		
6.	<p>Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бусад залуучуудтай хамт, ижил гараанаас сурч, боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлэх үүднээс дараах арга хэмжээг төрийн байгууллага, төрийн бус байгууллага, сургуулийн удирдлага, багш, эмч нар болон бусад холбогдох этгээдтэй хамтран хэрэгжүүлэх, тэдний санал санаачилгыг дэмжих, хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах зохицуулалтын механизмыг бүрдүүлэх замаар дараах арга хэмжээг авна:</p> <ul style="list-style-type: none"> • бүх шатны сургуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сурч боловсрох нөхцөлийг хангах үүднээс тэдэнд сургуульд орох, гарах, шаардлагатай анги танхимд очих, хичээлээ 		<p>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам,</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам</p>	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

	<p>ойлгоход нь туслах зорилго бүхий туслах үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр боловсролын байгууллагуудыг хангах;</p> <ul style="list-style-type: none"> • сургалтын материал, сурах бичиг, гарын авлагыг брайль хэл дээр боловсруулах, хэвлэх; • хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бэрхшээл болгоны онцлогоос хамаарч, холбогдох багш, сурган хүмүүжүүлэгч, туслах үйлчилгээ үзүүлэгчдийг бэлтгэн гаргах, тэднийг боловсролын байгууллагуудад ажиллах бололцоог хангах; 				
7.	Их, дээд сургуулийн суралцагч нь үндсэн мэргэжил ба дэд мэргэжил гэсэн хос мэргэжлээр суралцах боломжийг бүрдүүлнэ.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага	
8.	Их, дээд сургуулиуд ба төгсөгчдийн хоорондын эргэх холбоог хангуулах,		Хөдөлмөрийн яам	Боловсрол, соёл, шинжлэх	

	төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлд байршиж буй үзүүлэлтийг бодитойгоор тооцсон, шударга шалгуур бүхий хөндлөнгийн рейтингийн системийг нэвтрүүлнэ.			ухааны яам	
9.	Оюутан залуучуудад цагаа зөв зохистой өнгөрүүлэх боломж олгох үүднээс их дээд сургуулийн дэргэд урлаг, спортын дугуйлан хичээллүүлэхийг дэмжих, бүх нийтийн номын сангийн чанар хүртээмжийг сайжруулна.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
10.	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын чанарыг сайжруулах, оюутан залуучуудыг төгсөөд ажил эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байраар хангах боломжийг бүрдүүлнэ.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Хөдөлмөрийн яам	
11.	Хичээл сургуульдаа тодорхой амжилт гаргасан, үе тэнгийнхнийгээ эрдэм ном авьяас чадвараараа тэргүүлж буй залуучуудыг гадаадын төдийгүй дотоодын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, бусад тэтгэлэгт		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

	хөтөлбөрөөс ялгагдах онцлог бүхий үндэсний хэмжээний тэтгэлэгт хөтөлбөр бий болгох, жил бүр зохион байгуулна.				
12.	Мэргэжлээрээ үр бүтээлтэй, амжилттай ажиллаж байгаа болон гоц авьяастай оюуны өндөр чадвартай өсвөр үе залуучуудын оюуны бүтээл хөдөлмөр, бодит санал санаачилгыг нь дэмжих, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
13.	Их дээд сургуулийн залуу багш, оюутны шилдэг бүтээлийг олон нийтэд таниулах, судалгаа шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх, мэдлэг бизнесийн түншлэл бүтээлч хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго бүхий залуу багш, оюутны үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний бага хурлыг дэмжих, тэндээс гарсан бодит санал санаачилгыг хэрэгжүүлэхийг дэмжих, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
14.	Түүх соёл, нийгэм эдийн засаг, ёс заншил, хүний хөгжил, бүтээн байгуулалт, шинэ содон мэдээллийг түгээх, залуучуудын боловсролд хөрөнгө оруулах, зөв хувь хүн болгон		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

	төлөвшүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой сургалт, сурталчилгааны арга хэмжээг дэмжинэ.				
15.	Орчин үеийн техник, технологийг ашигласан онлайн сургалтын системд хамрагдан боловсрол эзэмших нөхцөлөөр залуучуудыг хангана.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төрийн байгууллага	
Зорилт 3. Залуучуудын онцлог, хэрэгцээнд нийцсэн, чанартай эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох					
1.	Залуучуудад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ, мэргэшсэн хүний нөөцийг хөгжлийн талаар тухайлсан салбарын бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.		Эрүүл мэндийн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
2.	Залуучуудын дунд эрүүл амьдралын хэв маягийг бүрдүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, зарим өвчний хор нөлөөг таниулах чиглэлээр нөлөөллийн болон сургалтын ажлуудыг зохион байгуулах сургалт хийх сурталчлах, эрүүл мэндийн тодорхой асуудлаар холбогдох зөвлөгөө өгөх боломж бүхий төвүүдийг хот, хөдөө орон нутагт байгуулна.		Эрүүл мэндийн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

3.	Залуучуудын дундах архи тамхи болон бусад хорт зуршлын хэрэгцээг бууруулах, хорт зуршил, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, эрүүл зохистой хооллолтыг дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сургууль, гэр бүл, байгууллага хамт олны хүрээнд зохион байгуулна.		Эрүүл мэндийн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
4.	Эрүүл мэндийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, ДОХ/БЗДХ, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтуудыг, зохион байгуулах өргөжүүлэх, тогтмолжуулна.		Эрүүл мэндийн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
5.	Залуучуудад үе тэнгийнхнээр дамжуулан эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн боловсрол олгогчдын ур чадварыг дээшлүүлэх, шинэлэг арга барил эзэмшүүлэх талаар олон улсын туршлага судлах тэдэнтэй хамтарч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.		Эрүүл мэндийн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
6.	Залуучуудад илүү өртдөг өвчин эмгэгийн талаар төрөл бүрийн зөвлөгөө өгөх, шинжилгээ хийх төвүүдийг нэмэгдүүлж залуучууд жилд нэг удаа үнэгүй шинжилгээ, оношилгоонд		Эрүүл мэндийн яам	Төрийн байгууллага	

	хамрагдах боломжоор хангана.				
7.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бэрхшээлийг тогтоох, түүнд нь тохирсон нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэл зүйн эмчилгээ хийх олон улсын туршлагыг судлах замаар энэ төрлийн тусгайлсан эмчилгээг улсын эмнэлгүүдэд нэвтрүүлнэ.		Эрүүл мэндийн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
8.	Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй, үр дүнтэй, хүртээмжтэй болгоно.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Нийгмийн даатгалын ерөнхий газар	
9.	Гэр бүлийн болон сургууль, ажлын байранд үүсэж болох төрөл бүрийн сэтгэл гутрал, хямралын эсрэг сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмчилгээ хийх боломж бүхий тогтмол үйл ажиллагаа бүхий төвийг байгуулна.		Эрүүл мэндийн яам	Төрийн байгууллага	
10.	Бүх нийтийн биеийн тамир, спортын хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх, хүрээг тэлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, залуучуудын		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

	чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх боломж бүхий үйлчилгээний төвүүдийг бий болгох, цэцэрлэгт хүрээлэн барих, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, импортлоход татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бий болгоно.				
Зорилт 4. Залуучуудын хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлэх					
1.	Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж, хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй мэргэжилтэн бэлтгэнэ.		Хөдөлмөрийн яам	Их, дээд сургуулиуд	
2.	Залуучуудыг мэргэжлээ сонгох явцад мэргэжлийн талаар ойлголт өгөх, мэргэжил сонгох зөвлөгөө өгөх, хамгийн хэрэгцээтэй байгаа ажлын байрны талаар жагсаалт гарган сурталчлах, үзэсгэлэн яармаг зохион байгуулна.		Хөдөлмөрийн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага	
3.	Хөдөлмөрийн үнэлэмжийг өөрчлөх, хийж бүтээснээр нь үнэлдэг болох, суралцахын хажуугаар цагаар ажиллан хөлсийг өдөрт нь олгодог ажлын байр бий болгох, энэ талаар ажил олгогч		Хөдөлмөрийн яам	Аж ахуйн нэгж байгууллага	

	байгууллагын санал санаачилгыг дэмжинэ.				
4.	Залуучуудыг ажлын байраар хангах, эзэмшсэн мэргэжлийнх нь хүрээнд дадлагажуулах боломжийг бүрдүүлнэ.		Хөдөлмөрийн яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага	
5.	Дээд боловсролтой, ахисан түвшний судалгааны ажил эрхэлж байгаа залуу хүмүүст зориулсан цагийн ажлыг бий болгох үүднээс төрийн албанд судалгаа, шинжилгээний чиглэлийн цагийн ажлын квотыг их, дээд сургуулийн докторантурын хөтөлбөрүүдтэй харилцан уялдаатайгаар бий болгоно.		Хөдөлмөрийн яам	Төрийн байгууллага	
6.	Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэг болох хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, нэн ядуу, өнчин, орон гэргүй, хараа хяналтгүй хүүхэд, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт байгаа хүүхдүүд, өрх толгойлсон залуу эцэг, эх, хорих ангид хоригдож буй залуучуудыг ажлын байраар хангах, тэдэнд хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.		Хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
7.	Их, дээд сургууль, төгсөгчдийг сургуулиа төгссөний дараа орон нутагт сэтгэл хангалуун ажиллах амьдрах		Хөдөлмөрийн яам	Аймаг, сумын Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн	

	боломжийг бүрдүүлнэ.			байгууллага	
8.	Аж үйлдвэржилт, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх замаар хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрны тоог нэмэгдүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулна.		Хөдөлмөрийн яам	Төрийн байгууллага, аж ахуйн нэгж	
9.	Залуучуудад бизнес эрхлэх, амьдрал ахуйгаа дээшлүүлэх нөхцөл боломжийг судалж бүрдүүлэх, бизнес эрхлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
10.	Гадаадад боловсрол эзэмшсэн, өндөр ур чадвар бүхий залуучуудыг эх орондоо сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, шинэ ажлын байр бий болгоно.		Хөдөлмөрийн яам	Төрийн байгууллага	
11.	Анх ажилд орж байгаа залуучуудад ажил олгогчийн зүгээс тавьдаг босго шаардлагыг багасгах, тэднийг дэмжинэ.		Хөдөлмөрийн яам	Төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага	
12.	Залуучуудын ажлын байран дахь хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах ажлыг олон улсын стандарт, туршлагын дагуу удирдлага,		Хөдөлмөрийн яам	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо	

	арга зүйгээр хангаж, ажлын байрны нөхцөл, аюулгүйн техник, хувцас, хэрэгсэл, тоноглолоор хангагдах эрхийг бодитой бий болгоно.				
13.	Гадаадад ажил, хөдөлмөр эрхэлж байгаа залуучуудын нийгмийн даатгал, хамгааллын үйлчилгээнд хамрагдах боломжоор хангана.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Нийгмийн даатгалын ерөнхий газар	
Зорилт 5. Залуучуудын орон байрны хэрэгцээг хангах төрөл бүрийн шийдлүүдийг бий болгох					
1.	Залуучуудын орон байрын хэрэгцээг хангах зорилгоор хот болон хөдөө орон нутагт залуучууд болон залуу гэр бүлд зориулсан хямд үнэ бүхий чанартай орон байр, орон сууцны хорооллуудыг шинээр барихад аж ахуйн нэгжүүдэд бодит хөшүүрэг бий болгох, хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авна.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Барилга, хот байгуулалтын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
2.	Залуучууд болон залуу гэр бүлд хувийн орон байртай болох боломжийг бий болгох үүднээс урьдчилгаа төлбөргүйгээр, бага хүүтэй, урт хугацааны зээлд хамрагдах таатай		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага	

	нөхцөлийг бүрдүүлнэ.				
3.	Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагын удирдлагын зүгээс залуу ажилтнуудаа хямд өртөг бүхий чанартай орон байртай болгох төслийг амжилттай хэрэгжүүлсэн байгууллага болон энэ төрлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй байгууллагуудад туршлага солилцох боломж олгох үүднээс холбогдох өдөрлөгийг тогтмол хугацаанд зохион байгуулах, байгууллагуудыг мэдээ мэдээллээр хангана.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
4.	Орон байр худалдан авах боломжгүй залуу гэр бүл, нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэгт зориулж хямд үнэ, бүрэн тоноглол, бүрэн тавилга, үйлчилгээ бүхий хөлсний болон нийтийн байрууд барих зорилт дэвшүүлж төр, хувийн хэвшлийн хамтын түншлэл байгуулах болон бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Барилга, хот байгуулалтын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
5.	Алслагдсан сум сууринд мэргэжилтэй залуу боловсон хүчин ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс орон байртай болоход хөнгөлөлт үзүүлэх, үүнээс гадна хүүхдийн цэцэрлэг, сургууль эмнэлгийг бий болгоно.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Барилга, хот байгуулалтын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

6.	Хот хөдөө орон нутагт оюутан залуучуудын сурч, амьдрах нөхцөлийг орчин нөхцөлийг хангахуйц оюутны дотуур байр шинээр нэмж барих, одоо байгаа оюутны дотуур байрнуудын орчин нөхцөлийг сайжруулна.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Барилга, хот байгуулалтын яам	Төрийн байгууллага	
7.	Орон гэргүй, нэн ядуу, архи согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх бодис донтсон зэрэг нийгмийн дэмжлэг шаардлагатай залуучуудад сэтгэл засал, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ, хордлого тайлах, хооллох зэрэг үйлчилгээ бүхий тусгай зориулалтын байруудыг барьж байгуулах, үйлчилгээг нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр шийдвэрлэх асуудлыг олон улсын туршлага, олон улсын байгууллагуудын тусламж, зөвлөгөөнд тулгуурлан бий болгоно.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам,	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
8.	Залуучууд, залуу гэр бүлд хямд өртөг бүхий орон сууц худалдан авах, хөлслөхөд зориулж төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар тогтмол		Барилга, хот байгуулалтын яам		

	МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ӨГНӨ.				
Зорилт 6. Нийгэм дэх залуучуудын эерэг дүр төрхийг бий болгох					
1.	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй контентыг залуучуудад зөв, хүмүүжил төлөвшил бий болгоход түлхүү чиглүүлж, залуучуудын талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээ мэдээллийг түгээхээс татгалзах талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүнийг төлөөлөх байгууллагуудтай зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Мэдээллийн технологи шуудан харилцаа холбооны газар, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үндэсний хэмжээний төрийн бус байгууллага	
2.	Олон улсад болон дотоодод мэргэжлийн ур чадвар, манлайлал, ёс суртахуун зэргээр үлгэж жишээ болж, амжилт гаргасан залуучуудын манлайллыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлах, олонд түгээнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Мэдээллийн технологи шуудан харилцаа холбооны газар, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үндэсний хэмжээний төрийн бус байгууллага болон бусад төрийн болон төрийн бус байгууллага	
3.	Монгол залуучуудын ухаалаг, орчин нөхцөлд хурдан зохицож, хөрвөх чадвар сайтай, тусархаг гэх Монгол залуу хүний эерэг дүр төрхийг дотоодод болон олон улсын түвшинд бий болгох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан			Мэдээллийн технологи шуудан харилцаа холбооны газар, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үндэсний хэмжээний төрийн бус байгууллага болон бусад	

	сурталчлан таниулна.			төрийн болон төрийн бус байгууллага	
Зорилт 7. Залуучуудын оролцоог дэмжих механизмыг бий болгох					
1.	Залуучуудыг нийгэм, соёл, улс төрийн асуудлаар өөрсдийн дуу хоолойг хүргэх, шийдвэр гаргах түвшинд оролцох боломжоор хангах, тэдний бодит санал санаачилгыг дэмжих замаар оролцоог хангах механизмыг бүрдүүлнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам,	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
2.	Залуучуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулах, залуучуудын сонгуулийн идэвх оролцоог сайжруулах талаар судалгаа хийж, үр дүнд хүргэнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Сонгуулийн ерөнхий хороо	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
3.	Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас санаачилсан залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, сайжруулах үр дүн бүхий төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгоно..		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам,	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
4.	Залуучуудын авьяас чадварыг дэмжин, соёл урлаг, спортын арга хэмжээнд		Хүн амын хөгжил, нийгмийн	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын	

	оролцох, түүх, соёл, уламжлалт зан заншлаа хамгаалан хөгжүүлэхэд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.		хамгааллын яам,	байгууллага	
5.	Оюутнуудын нийгмийн оролцоог идэвхжүүлэх, дэмжих үүднээс тэдний хийж буй нийгмийн сайн сайхны төлөөх сайн дурын ажлыг кредитжүүлэх кредитийн системийг бий болгоно.		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам,	
6.	Оюутны байгууллагад тодорхой асуудлаар төсөв хөрөнгийн эрх мэдэл олгох хариуцлагажуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам,	-	
7.	Сургууль хамт олны орчинд комьюнити радио, сонин хэвлэлийг залуучуудын санал, санаачилга, оролцоотойгоор бий болгох уг үйл ажиллагааг дэмжинэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам,	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
8.	Залуучуудыг улс орон, нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс улс төрийн оролцоог дэмжих, сонгуульд идэвхтэй санал өгдөг болгох механизмыг бүрдүүлнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам,	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
<p>Зорилт 8. Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэгт зохистой арга, хэлбэрээр хүрч</p> <p>ажиллах</p>					

1.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бэрхшээл болгоны онцлогоос хамаарч албан ёсны ангиллыг батлах ажлыг Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.		Эрүүл мэндийн яам	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	
2.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын нийгэмд ажиллаж амьдрах дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд зорчих зам талбай олон нийтийн газар, нийтийн тээврийн хэрэгсэл, нийтийн бие засах газрыг хэвийн хэрэглээний шаардлагыг хангах түвшинд хүргэх холбогдох стандартыг батална.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Стандартчилал хэмжил зүйн газар болон холбогдох төрийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага	
3.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад нийгмийн өдөр тутмын амьдралд оролцоход нь туслах зорилго бүхий туслах үйлчилгээг бий болгох, туслах үйлчилгээ үзүүлэгчдийг бэлтгэх албан ёсны сургалт зохион байгуулах, сургууль, албан байгууллагад туслах үйлчилгээ үзүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх, туслах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх туслах		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

	үйлчилгээний зардлыг батална.				
4.	Их дээд сургуульд тэнцсэн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сургалтын төлбөрийг бүрэн хэмжээнд олгоно.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага	
5.	Залуучуудыг сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад чиглүүлнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	-	
6.	Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэг болох хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт байгаа хүүхдүүд болон гэр оронгүй, бүтэн өнчин, асран хамгаалах хүнгүй хүүхдүүд, асрамжийн газраас гарч буй залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, архи, мансуурах болон сэтгэцэд нөлөөлөх эм бодисонд донтсон залуучуудад зориулсан тусгайлсан үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг дэмжинэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, олон улсын байгууллага	
7.	Хорих ял эдэлж байгаа залуучуудад иргэний болон эрх зүйн боловсрол олгох, сэтгэл зүйн мэргэжлийн тусгай радио хөтөлбөрийг бий болгоно.		Төслийн нэгж	Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
8.	Хорих ял эдэлж буй залуучуудад боловсрол мэргэжил олгох, хорих			Хууль зүйн яам, Боловсрол соёл, шинжлэх	

	ангиас суллагдах үед үргэлжлүүлэн сурах, ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг Хууль зүйн асуудал төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.		Хөдөлмөрийн яам	ухааны яам	
<p>Зорилт 9. Залуучуудын байгууллага, залуучууд судлалыг тууштай хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>					
1.	Залуучуудад тулгарч буй асуудлыг нийгмийн салбар бүрээр тодорхойлох, төрөөс залуучуудад чиглэсэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд хяналт үнэлгээ хийх аргачлалыг сайжруулах зорилгоор залуучуудад чиглэсэн үндэсний хэмжээний судалгаа болон бусад судалгааг хийх, тогтмол тайлан гаргах, залуучууд судлалыг хөгжүүлэх механизмыг бүрдүүлнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам		
2.	Залуучуудад чиглэсэн судалгааны ажлыг нээлттэй, ил тод сонгон шалгаруулалт зарлаж залуучуудын асуудлаар мэргэшсэн төрийн бус байгууллага, судлаачдын багаар		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

	гэрээний үндсэн дээр хийлгэнэ.				
3.	Залуучуудад чиглэсэн бодлогын болон академик түвшний судалгаанд зориулсан тэтгэлэгт хөтөлбөрийг жил бүр зохион байгуулна.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	
4.	Залуучуудад чиглэсэн судалгаа хийх мэргэжилтэн, төрийн бус байгууллагыг нэмэгдүүлэх, судалгааны арга зүйг сайжруулах, судалгаанаас гарсан үр дүнг үнэлэх, хэрэгжүүлэх арга механизмыг бүрдүүлнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	-	
5.	Залуучуудад чиглэсэн судалгааны сэдвийг тодорхойлох, нарийвчлах, судалгааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, өмнөх жилийн судалгааны үр дүнгийн биелэлтийн талаар дүгнэх зорилгоор төрийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, залуучуудын асуудлаар дагнасан судалгаа явуулдаг судлаачид, залуучуудын төлөөллийг оролцуулсан зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулна.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	-	
6.	Залуучуудын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, тухайн байгууллагуудын мэргэжилтнүүдийн чадавхийг		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	

	сайжруулах, хамтарч залуучууд руу чиглэсэн төрөл бүрийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.			
7.	Хөтөлбөрийн хяналт үнэлгээг залуучуудын байгууллагаар дамжуулан гэрээний үндсэн хийлгэх механизмыг бүрдүүлнэ.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага
8.	Залуучуудын хөгжлийн талаарх төрөөс баримтлах бодлого, “Монгол залуу хүн” үндэсний хөтөлбөр болон бусад залуучуудад чиглэсэн төсөл хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, залуучууд руу чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын талаарх мэдээлэл, залуучуудад чиглэсэн улсын хэмжээний томоохон арга хэмжээ, судалгааны тайлан, төсөв хөрөнгийн талаарх мэдээ, мэдээллийг залуучуудад нээлттэй хүргэх үүднээс үндэсний хэмжээний портал сайт ажиллуулна.		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага